Undesnii
Shundan
6面
2019.10.2
(Wed)

# МОНГОЛД "ӨВСНИЙ ҮНДЭС" ХӨТӨЛБӨРӨӨР 400 ГАРУЙ ТӨСӨЛ ХЭРЭГЖЖЭЭ





Д.ЧАНЦАЛДУЛАМ

Япон Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-наас "Өвсний үндэс" хөтөлбөрийн хүрээнд 2018-2019 онд хийсэн ажлуудаа өчигдөр танилцууллаа. Тухайлбал, ХСҮТ-ийн байр нь 1982 онд ашиглалтад орсон бөгөөд өнөөг хүртэл дээвэртээ их засвар хийж байгаагүй аж. Харин "Өвсний үндэс" буцалтгүй тусламжийн санхүүжилтээр уг эмнэлгийн Б, В, Г хэсгийн 30 хувь буюу 1860 ам метр дээврийг бүрэн засварлаж дуусчээ. Үүнд нийт 200 сая төгрөг төсөвлөж, 172 сая орчим төгрөгөөр засварын ажлыг хийж дуусгасан байна. Үлдсэн 70 хувийг нь улсын төсвөөр засварлаж бүх блокын дээврийг засаж дууссан гэдгийг албаны хүмүүс онцоллоо. Мөн тус эмнэлэгт Японы Засгийн газраас орчин үеийн дэвшилтэд технологи бүхий ЭХО-ны иж бүрэн аппарат, эмнэлгийн зориулалтаар тоноглосон 25 сая төгрөгийн үнэтэй "Toyata hiace" маркийн түргэн тусламжийн машиныг бэлэглэсэн байна. Энэ талаар Япон Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны хоёрдугаар нарийн бичгийн дарга Ямашита Акихито "Японы Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөтөлбөр Монгол Улсад 1977 оноос хэрэгжиж эхэлсэн. Хамгийн анх барьж өгсөн барилга нь "Говь" үйлдвэр юм. Өнгөрсөн оны гуравдугаар сарын байдлаар буюу 40 гаруй жилийн хугацаанд Япон Улсаас Монгол Улсад нийт 370 сая ам.долларын тусламж үзүүлсэн байна. Мөн "Өвсний үндэс"



гаргасан. 2019-2020 онд "Өвсний үндэс" төслийн хүрээнд 20 орчим хөтөлбөрийг хэрэгжүүлээд явж байна"

ХСҮТ-ийн Чанарын албаны дарга Б.Баасанжав "Манай эмнэлэг хавдрын тусламж үйлчилгээг улс даяар үзүүлдэг цорын ганц байгууллага. Сүүлийн арван жилийн хугацаанд дээвэрт ямар нэгэн засвар хийгдээгүй. Энэ зун бороо хур элбэг байсан учраас дээврээс ус их гоожсон. Уг засварыг нийт 172 сая орчим төгрөгөөр хийж, нийт 200 сая төгрөгийг төсөвлөсөн, үлдсэн санхүүжилтийг дотоод заслын ажилд зарцуулахаар хүсэлт явуулаад байна. Мөн манай эмнэлгээр өнгөрсөн онд 12.3 мянган өвчтөн эмчлүүлсэн бол амбулаториор 93 мянга орчим хүн үзүүлсэн байна. Түүнчлэн жилд гурван мянган хүнд мэс засал, 600 мянган хүнд тунат эмчилгээ хийдэг. Дээврийн ажил хийгдсэнээр үйлчлүүлэгчийн нааж тав тух, аюулгүй байдал хангагдсан. Мөн "Өвсний үндэс" хөтөлбөрийн



нь байгуулагдаад 30 жил болсон бөгөөд нийт 14 бүлэгт 800 гаруй хүүхэд суралцдаг аж. Мөн сантехникийн бүрэн шинэчлэл огт хийгдээгүй тул олон хүндрэл гардаг байжээ. Тухайлбал, ашиглалтын явцад ... хүүхдүүд болон багш нарын угаалгын өрөө ... хүндрэлтэй байсан гэдгийг багш, ажилчид ярьж байв. Тус цэцэрлэгт "Өвсний үндэс" хөтөлбөрийн буцалтгүй тусламжаар цэвэр, бохир усны шугам засварлах, дотор засал, дулааны хангамжийн ажлыг хийжээ. Энэ ажлыг өнгөрсөн оны арваннэгдүгээр сард туршсан бөгөөд нийт 192 сая төгрөг зарцуулжээ. БЗД-ийн 129 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Я.Баасанхүү "Хүүхэд өсөж, хүмүүжихэд аюулгүй орчин хамгийн чухал юм. Бид "Өвсний үндэс" хөтөлбөрийн хүрээнд шугам, сүлжээгээ засварлах, ариун цэврийн өрөөгөө бүрэн тохижуулсан. Энэ ажилд манай цэцэрлэгийн ... эцэг, эх тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулсан. ... санхүүжилтийн тусламж

